



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/908

Мандалговь

Сургалтын төлбөрийн дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 60.1.5, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн 4.2.2.3 дахь заалт, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдмийн Далай Цогцолбор сургуулийн англи хэлний багш Ням-Осорын Бямба-Эрдэнийг “Toefl-junior-Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдах сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сургалтын төлбөрт шаардагдах 650000 (Зургаан зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100614